225

53

# УЛААНБААТАР
# ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
# ТОГТООЛ

Улаан баатар хот.

1964-12-24 Дугаар 284.

( ГЗ-ны 1990 140 [illegible] )

БАЯН ГОЛ ЗОЧИД БУУДЛЫН ДОТООД
ДҮРМИЙГ БАТЛАХ ТУХАЙ.

Улаанбаатар хотын АДХГүйцэтгэх Захиргааны хурлаас

ТОГТООХ НЬ:

~~I.Улаанбаатар хотын АДХГүйцэтгэх Захиргааны Баянгол зочид буудлын~~ дотоод дүрмийг баталсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХГ ЗАХИРГААНЫ
I-Р ОРЛОГЧ ДАРГА З. Ширнин ШИРНИН
ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА ДАМДИНСҮРЭН

Нийлсэн. . .
боловсруулсан
зөвшөөрсөн. . . . .
IO%.ЦС.Х. . . . . .

226
-54-

**УЛААНБААТАР ХОТЫН АДХГҮЙЦЭТГЭХ**
ЗАХИРГААНЫ I964 ОНЫ I2 Р САРЫН
24 НЫ ӨДРИЙН 284 Р ТОГТООЛООР.
БАТЛАВ.

Баянгол зочид буудлын дотоод дүрэм.

Нэг. Ерөнхий зүйл.

I. Баянгол зочид буудал нь улаанбаатар хотын АДХ гүйцэтгэх Захиргааны шууд захирагдах бие даасан аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллах байгууллага болно.

2. Гадаадаас түр хугацаагаар ирж ажиллах мэргэжилтэн, ба дотоодын нам улсын чанартай хурал зөвлөлгөөн семинар, курсд ирэгсдийг Баянгол зочид буудалд хүлээн авч боловсон үйлчилгээгээр хангах үйл ажиллагааг явуулна.

3. Зочид буудал нь өөрийн үйл ажиллагааг явуулахдаа өөрийн район байгууллагдаж үйлчилгээний төрөлбүрийн салбаруудыг түшиглэн явуулахын дээр тэдний бүх үйл ажиллагааг БНМАУ-аас дагаж шийтгүүлж байгаа хууль дүрэм ба Улаанбаатар хотын АДХГ Захиргааны заавал биелүүлэх шийдвэрт заагдсан хэв хэмжээг баримтлан удирдана.

4. Зочид буудал нь батлагдсан өөрийн тусгай тамга ба бичгийн хуудастай байна.

ХОЁР. Зохион байгуулалтын талаар.

I. Баянгол зочид буудлын дарга гэж нэрлэх ба өөрийн ажлын талаар улаанбаатар хотын АДХГүйцэтгэх Захиргааны дарга түүний орлогч нарт шууд захирагдана.

2. Зочид буудлын дарга нь захиран удирдаж зохиож байгуулах бүхий л үйл ажиллагаагаа, орлогч дарга буудлын захирагч паспортын эрхлэгч санхүүгийн нярвуудлагатан нараар дамжуулан явуулна.

3. Зочид буудлын даргад шууд захирагдах хүмүүсүүд нь:

а. Орлогч дарга
б. Ерөнхий ня-бо
в. Боловсон хүчин
г. Жижүүрын захирагч паспортын эрхлэгч зохион байгуулагч,

д.Буудлын эмч
е.Цахилгааны техник
ё.Сантехникийн техник
ж.радио телефоны техник
з.Авто үйлчилгээний дарга бөгөөд механик
и.Ресторанын дарга
й.Угаалга,индүү оёдолын тасгийн эрхлэгч
к.үсчин гоо сайхны үйлчилгээний эрхлэгч
4. Буудлын орлогч даргад шууд захирагдах хүмүүс.
а.Складуудын няравууд
б.Комендант
в.бэлтгэгч
д.буфетийн эрхлэгч
е.үйлчлэгч цэвэрлэгч нар
ё.хувцас өлгөгч
ж.цахилгаан шат ажиллуулагч ба монтёрууд
з.цэвэр бохир ус халаалтын бүх слесарууд
и.Хаалгач жижүүр нар
й.Дежур ба хамгаалалт байгуулагч нар

Гурав.Баянгол зочид буудлын үүрэг.

Улаанбаатар хотын АДХГ захиргааны Баян зочид буудал нь доорхи үүргүүдийг гүйцэтгэнэ.

1.Зочид буудал нь нам улс олон нийтийн байгууллагын улсын чанартай хурал зөвлөлгөөнд оролцох төлөөлөгчид ба тусгай албан хэргээр түр зорчигсодыг албан байгууллагын захиалгаар хүлээн авч үйлчлэхийн дээр гадаад орнуудаас тус улсад түр хугацаагаар ирж байгаа мэргэжилтэнүүдийг хүлээн авч үйлчлэх үүрэгтэй.

2.Зочид буудал нь өөрийн үйл ажиллагаанд социалист тайлан өөдөөг нэрийн сайн нэвтрүүлж улсаас өгөгдсөн төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тулд тэмцэл талбж социалист уралдааныг өрнүүлэн дүнгийн цаг тухайд нь дүгнэж байх үүрэгтэй.

3.Зочид буудал нь өөрийн ажилчин албан хаагчдын соёл хүмүүжил соёлч боловсон харьцаа,тэргүүний үйлчилгээний ажиллагааг өргөжүүлэн тэмээр үзгэлж ажиллаж хүмүүсийн одоо үеийн социалист боловсон

хамьдаанд суурган байх ёстой.

4.Зочид буудал нь хүмүүсийн ажлын зориуцлага сэжилга батыг эрс сайжруулж хүн нэг бүрийн мэргэжлийг улам дээшлүүлэх,гадаадын мэргэжилтнээс цуцалтгүй суралцах ажлыг тодорхой төлөвлөгөөтэй явуулана.

5.Зочид буудал нь өөрийн бүх үйл ажиллагаандаа тус улсын дотор дагаж мөрдөгдөж байгаа хууль дүрэм тогтоол шийдвэр дээд байгууллагуудын тушаалуудыг удирдлага болгон биелүүлэх үүрэгтэй.

6.Зочид буудал нь ажилчин албан хаагчдын хөдөлмөр хамгаалалтын бүх шаардлагуудыг хэрэгжүүлэн биелүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

дөрөв.Баянгол зочид буудлын эрх.

I.Зочид буудал нь тус улсын албан үйлдвэр,нэгдэл сангийн аж ахуй,бусад соёл урлагын байгууллагуудтай бие даан гэрээ хэлэлцээр хийх эрхтэй.

2.Зочид буудал нь харилцах данс нээж улсын банкны бусад ажиллагааны талаар хуулийн эрх бүхий ажил явуулалтыг тогтоож шүүх арбиторын өмнө нэхэмжилгээ бичих ба хариуцах эрхтэй.

3.Зочид буудал нь өөрийн үйл ажиллагаатай шууд холбогдсон асуудлаар тушаал захируудыг гаргана.

4.Зочид буудал нь өөрийн шууд захирагдсан дээд байгууллагын гаргасан тушаал заавар,удирдамжууд болон тус улсын хөдөлмөрийн ба засаг захиргааны эрхийн хэв хэмжээг үндэслэн байгууллагын дотоодод мөрдөх зааваруудыг гаргаж дагаж мөрдүүлнэ.

5.Зочид буудал нь батлагдсан орон тоонд захируулан ажилчин албан хаагчдыг ажилд авах ба халах эрхтэй,ажилчин

албан хаагчдыг урамшуулан шагнах буюу ажлын сахилга бахиг алдагдуулсан хүмүүсийг сануулах, зэмлэх, ажлаас халах тухайг урьдчилан сануулж, халаж бага цалинтай ажилд гурван сарын хугацаагаар томилох эрхтэй болно.

6. Зочид буудлын зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах санал боловсруулж дээд байгууллагад тавих эрхтэй.

7. Байшин барилга, хөрөнгө хогшлуудыг дээд байгууллагын зөвшөөрөлөөр худалдан авах ба захиалах түрээслэн хэреглэх, бусдад хөлсөөр хэрэглүүлэх эрхтэй.

8. Зочид буудал нь зочидын үйлчилгээнд тохирохгүй болсон ба хэрэгцээнээс илүүдсэн эд хогшлыг дээд газрын зөвшөөрөлтэйгээр бусад газарт шилжүүлэх буюу борлуулах эрхтэй.

Хянасан. . . . .

Боловсруулсан. . . .

10%.ЦО.Х. . . . . . .